



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар Б/26

Өмнөдэлгэр сум

О.Гансүрэнг ажилд томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2 дах заалт, 12.16 дах зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалт, Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 06, 2023 оны 240, 2024 оны 84, 238 дугаар тогтоол, байгууллагын дотоод журмын 13.1, 13.4 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Отгонбулагийн Гансүрэнг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээнд заасан хугацаанд монгол хэл, бичиг, уран зохиолын багшаар томилсугай.

2. Багш О.Гансүрэнгийн үндсэн цалинг ТҮБД-3 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянга) шатлалаар тогтоосугай.

3. Багш О.Гансүрэнд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, багшийн ёс зүйн дүрэм болон байгууллагын дотоод дүрэм журмыг чандлан сахиж хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА

